



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/331

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Тэшиг суманд баригдах конторын барилгын ажил”-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Зууны сод хийц” ХХК-тай 2,429,508,888 (хоёр тэрбум дөрвөн зуун хорин есөн сая таван зуун найман мянга найман зуун наян найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Зууны сод хийц” ХХК-ийн захирал (Б.Амарбат)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 06-ны/ний өдрийн
 А/331 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	41,526,809	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Захиалагчийн техник хяналтын зардал	41,526,809	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	20,763,404	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	37,980,000	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
5	Нормчлолын сан	3,737,413	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
9	Ажил гүйцэтгэх хугацаа	2026.05.01-2026.10.31 2027.05.01-2027.11.30 (Хуанлийн 390 хоногт багтаан гүйцэтгэнэ)	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)

--o0o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 06-ны/ний өдрийн
А/33А дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Чинзориг	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Халаалт агаар сэлгэлтийн инженер	М.Нарангэрэл	
3	Усан хангамж, ариутгах татуургын инженер	Б.Энхбаяр	
4	Цахилгааны инженер	М.Лувсанчой	
5	Холбоо дохиолол, мэдээллийн инженер	Б.Содномцэрэн	
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	М.Цогтбаатар	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар, хэмжээ	
1	Ачааны автомашин	2125 УКН	
2	Ачааны автомашин	2170 БУЛ	
3	Автокран	7610 УАО	
4	Эксковатор	1122 ММВ	
5	Бетон зуурагч	0.5 м3	
6	Авто ачигч	6960 УР	

--о00о--